



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 182

Улаанбаатар хот

Г

Эрх шилжүүлэх тухай

Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг болон 2015 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 22 дугаар тоот “Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүх”-ийн шийдвэр, 2015 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 128 дугаар тоот “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх”-ийн магадлал, 2015 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 107 дугаар тоот “Монгол улсын Дээд шүүхийн Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх”-ийн хуралдааны тогтоол, 2015 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 63 дугаар тоот “Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн гүйцэтгэх хуудас”, 2016 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 150/07 дугаар тоот “Шүүхийн шийдвэр, тогтоол”-ыг биелүүлэх мэдэгдэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2016 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын XVII.1.3.19 Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж төсөл арга хэмжээний хүрээнд Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 63 дугаар тоот тушаалаар батлагдсан /Өргөө амаржих газар/ ажлын 77,500,000 /Далан долоон сая таван зуун мянган/ төгрөгийн төсвийн зарцуулах эрх /гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх/-ийг Өргөө амаржих газрын дарга /Д.Энхбаяр/-д шилжүүлсүгэй.
2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг Өргөө амаржих газрын дарга /Д.Энхбаяр/-д даалгасугай.
3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Баярсайхан/-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ОЮУНБААТАР



080274